



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

“Монгол газрын тос боловсруулах
үйлдвэр” ХХК-ийн 2018 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.2.11, Компанийн дүрмийн 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 5-д заасан төсөл, арга хэмжээг хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

2.Компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлт, төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Д.Цэрэнноровт даалгасугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002195

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн
38 дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨРИЙН ӨМЧИТ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

| Д/д | Төсөл арга хэмжээний нэр | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Төсөвт өртөг | 2018 онд санхүүжих /мян.төг/ |
|-------|---|------------|----------|--------------------|------------------------------|
| 5 | Үйлдвэрийн талбай бэлтгэх ажил | | | 5,941,150.0 | 5,941,150.0 |
| 5.1 | Үйлдвэрийн хашаа барих ажил | | | 2,187,164.2 | 2,187,164.2 |
| 5.1.1 | Угсармал төмөр бетон хашаа (өндөр 2.5м), м2 | 12,500 | 45,500 | 643,370.0 | 643,370.0 |
| 5.1.2 | Бетон хашаа дээгүүр татах хамгаалалтын өргөстэй тор, метр | 5,000 | 800 | 4,480.0 | 4,480.0 |
| 5.1.3 | Бетон хашаа доогуур шороогоор хаяавч хийж манах, метр3 | 750 | 77,200 | 58,479.0 | 58,479.0 |
| 5.1.4 | Гэрэлтүүлгийн ажил /6м өндөртэй шон, ширхэг/ | 500 | 450,000 | 227,250.0 | 227,250.0 |
| 5.1.5 | Харуулын барилга угсралтын ажил /цамхагтай, 4ш/ м2 | 36 | 420,000 | 15,271.2 | 15,271.2 |
| 5.1.6 | Камержуулалтын ажил, ширхэг | 8 | 400,000 | 3,584.0 | 3,584.0 |
| 5.1.7 | Үерийн далангийн ажил, у/м | 5000 | 194,600 | 982,730.0 | 982,730.0 |
| 5.1.8 | Усны худгийн хамгаалалтын хашаа (1.5м x 1.5м), ойн зурвас, ногоон байгууламжийн хашаа | 5,625 | 40 | 252,000.0 | 252,000.0 |
| 5.2 | Үйлдвэрийн талбайн газар шорооны ажил, м2 | | | 3,753,958.8 | 3,753,958.8 |
| 5.2.1 | Өнгөн хөрсний хуулалт | 40,000 | 8 | 320,000.0 | 320,000.0 |
| 5.2.2 | Ухах шорооны хэмжээ | 136,148.2 | 8 | 1,089,185.8 | 1,089,185.8 |
| 5.2.3 | Дүүргэх шороо | 190,800 | 6 | 1,144,800.0 | 1,144,800.0 |
| 5.2.4 | Нягтруулах газар | 60,000 | 20 | 1,200,000.0 | 1,200,000.0 |